

**НИЙСЛЭЛИЙН
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
 ТУШААЛ**

2017 оны 01 сарын 18 өдөр Дугаар 104 Улаанбаатар хот

Мэдээлэл авах тухай

Эрүүл мэндийн сайдын 2013 оны "Химийн бодисын хордлогыг тэнгэх, мэдээлэх журам" 487 дугаар тусгаал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн "Хүнсний аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 19 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр нийслэлийн Баянгол дүүрэгт хордлого байж болзошгүй шалтгааны улмаас хүмүүс амиа алдсантай холбогдуулан хордлогын үед хэрэглэх эм, эмнэлгийн хордлогын нөхцөлийг бүрдүүлэн болон байдлыг хангах, архины хордлоготой хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ нарийвчилсан үзлэг хийж, ноцтой буюу хордлогын сэмжг бүхий хүн илэрэл яаралтай мэдээлэх, архины хордлогоос сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг эрхэмжүүлэн ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга, харьяа байгууллагын дарга, захирал, ерөнхий эмч нарт үүрэг болгосугай.
- Үүсэн нөхцөл байдлын улмаас Нийслэлийн эрүүл мэндийн газарт ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, "Мэдээлэл авах, өгөх түр журам"-ыг хүснэгтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Хариуцлагатай жижүүрийн мэдээ, болзошгүй цагийн байдалтай холбоотой яаралтай мэдээлэл газрын дарга, удирдлагыг шуурхай хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга / М.Мөнхдэлгэр/д үүрэг болгосугай.
- Тусгаарын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /О.Баяр/д даалгасугай.

ДАРГА ТӨМӨРБААТАР

1150500009

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН 2017 ОНЫ 01 САРЫН 18 ӨДРИЙН АЖИГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ 2

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ, ӨГӨХ ТҮР ЖУРАМ

Үндэслэл

Энэхүү түр журам нь 2017 оны 1 дүгээр сарын 16-нд Нийслэлийн Баянгол дүүргийн II хороонд байрлах "Ногоон төлөг" хотхонд аринд хордсон байж болзошгүй иргэд амиа алдсан эрэгт гявцалтай холбоотой ариндан согтуурсны улмаас харьяа байгууллагуудад эмнэлгийн тусламж авсан, архи, метилийн спиртын хордлого байж болзошгүй сэмж бүхий хүн илэрсэн тохиолдолд яаралтай мэдээлэл авах, цуглуулсан мэдээлэл хэлбэгдэх байгууллагууд дамжуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Мэдээ, мэдээлэл авах

- Хариуцлагатай жижүүр нь харьяа байгууллагуудаас аридан согтуурсны улмаас эмнэлгийн тусламж авсан хүмүүсийн мэдээллийг НЭМГ-ын 320981, 325054 утсаар оройн 20.00, 23.00, өглөөний 8.00 цагуудад авч, нэгтгэнэ.
- Харьяа байгууллагууд дээрх утсаар өөрийн байгууллагад түргэн тусламжаар болон өөрсдөө өрж тусламж, үйлчилгээ авсан хүмүүсийн мэдээллийг хүснэгтийн дагуу авч, НЭМГ-ын хариуцлагатай жижүүрт зөвхөн цагуудад мэдэлнэ.
- Хэрэв архи, согтууруулах ундаа, бусад төрлийн ахуйн шингэн ууж хэрэглэсний улмаас хүний биеийн байдал хүндэрсэн, хордлогын улмаас нас барсан тохиолдолд Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /М.Мөнхдэлгэр-99993228/, Гамшиг онцгой байдлын үеийн болон түргэн тусламжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Ш.Тэгшбаяр-99779568/ нарт тохиолдол тухай бүрт шуурхай мэдэлнэ.
- Хариуцлагатай жижүүр нь харьяа байгууллагын мэдээллийг нэгтгэн ЭМН-ны Шуурхай удирдлагын төвийн 261629, Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвийн 310005 утсаар болон www.nogoonibg.ub.gov.mn, www.dispatcher_ub@yahoo.com цахим хангаар мэдээллийг өгнө.

МЭДЭЭ АВАХ ХҮСНЭГТ

№	Байгууллагын нэр	Тусламж үйлчилгээ авсан хүний тоо	Хүнд хүний мэдээлэл /овог нэр, нас хүйс, хүлээн авахад ирсэн цаг хугацаа, биеийн ерөнхий байдал	Мэдээ өгсөн хүний нэр, албан тушаал, холбогдох утас



Нийслэлийн эрүүл мэндийн газрын
дэргэн 2017 оны 01 сарын 18 өдрийн
10 дугаар тушаалын хавсралт 1

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Хариуцлагатай жижүүрийн нэрс	Албан тушаал	Жижүүрт гарах өдөр, цаг	Хяналт тавих албан тушаалтан
1	Б.Батцэцэг	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн	17/1-ний 18.00-18/1-ны 08.00	О.Баар Орлогч дарга
2	Р.Октябрь	Эх барих эмэгтэйн үндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	18/1-ний 18.00-19/1-ны 08.00	М.Мөнхдэлгэр Хэлтсийн дарга
3	Н.Мөндсайхан	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	19/1-ний 18.00-20/1-ны 08.00	Т.Хулан Хэлтсийн дарга

Жич: Хариуцлагатай жижүүрийн ажиллах хугацааг цаашид сонгах, эсэх талаар тухайн үед нь мэдээлнэ.